

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ “ХҮРЭЛ ГЭРЭГЭ” ӨРГӨМЖЛӨЛТ ЭКО 1-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ТАНИЛЦУУЛГА



Хүрэл Гэрэгэ



МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН АЛСЫН ХАРАА

Сургуулийн өмнөх боловсролыг чанартай олгон, эрүүл аюулгүй, ногоон орчинг бүрдүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандартыг хангасан жишиг цэцэрлэг болно.

МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Экологийн мэдлэгтэй, байгаль эх дэлхийг хайрлах, эерэг хандлагатай иргэнийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулна.

МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Эко орчин, нөхцлийг бий болгон, хүүхдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн туршилт, танин мэдэх үйлийг дэмжин, эрүүл чийрэг бие бялдартай, зөв дадал хэвшилтэй, өөрийгөө илэрхийлэх, хамгаалах чадварыг олгон, хүүхдийг төлөвшүүлэн хөгжүүлнэ.

ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ЗАМНАЛ



Цэцэрлэг байгуулах тухай

Дундговь аймгийн бага хурлын тэргүүлэгчдийн 1951.05.27-ны өдрийн 41 тоот хурлын тогтоолд: Ахуны цэцэрлэг байгуулах тухай

- Цэцэрлэгийн аж ахуйн бүх бүтэцлийг харуулах хангах, эрхлэгчид намын хороонд ажиллаж байсан Баянрагчийг 7.24-нөөс эхлэн ажиллуулсугай.
- Хүүхдийн илэрэлийг Аравын хувьсгалын Зөвлөлийн ойн наана байгуулж ажиллаланд оруулах
- 7 сарын 1-нөөс эхлэн цэцэрлэгийн жинхэнэ эрхлэгч ба хүүмүүдүүлэгчээр ажиллах хүмүүсийг бэлтгэж байсугай.
- Цэцэрлэгийн хэрэгтэнд шаардлагад давуу материал ба хөдөөн хэргэнийг цаг тухайд нь нийтүүлж байхыг хоршооцон холбоо н.Тувсаннарайт даалгасугай.
- Цэцэрлэгийн аж ахуйн зүйлүүдийг тагах тээвэрт хоршооцон холбоо хэлтэгийн тэргүүт 2.3 улам явуулахыг н.Цорон-Очир Дувсаншарын нарт даалгасугай.
- Цэцэрлэгийн аж ахуйг санхүүг хэлтэгийн дарга Гүрдоржид даалгасугай.



Дундговь аймгийн Сайнцагаан сумын 1-р цэцэрлэг нь аймгийн ууган цэцэрлэг бөгөөд, анх 1951 оны 05 сарын 27-ны өдөр Дундговь аймгийн Бага хурлын тэргүүлэгчдийн 41 тоот хурлын тогтоолоор:

Цэцэрлэгийн аж ахуйн бүх бэлтгэлийг хариуцаж хангах, эрхлэгчид намын хороонд ажилласан байсан Банзрагчийг 7 сарын 24-ны өдрөөс ажиллуулсугай.

Хүүхдийн цэцэрлэгийг Ардын хувьсгалын 30 жилийн ойн баярын наана байгуулж ажиллагаанд оруулсугай.

7 сарын 1-ээс эхлэн цэцэрлэгийн жинхэнэ эрхлэгч ба хүмүүжүүлэгчээр ажиллах хүмүүсийг бэлтгэж байсугай.

Цэцэрлэгийн хэрэгцээнд шаардагдах даавуу материал ба хоолны хэрэглэлийг цаг тухайд нь нийлүүлж байхыг хоршоодын холбоо н.Лувсаншаравт даалгасугай.

Цэцэрлэгийн аж ахуйн зүйлүүдийг татах, тээвэрт хоршоодын холбоо хэлтэсийн тэргийг 2-3 удаа явуулахыг н Цэрэн-Очир, Лувсаншарав нарт даалгасугай.

Цэцэрлэгийн аж ахуй, санхүүг хэлтсийн дарга Гүрдоржид даалгасугай, гэх мэт шийдвэрүүдээр аймгийн анхны ууган цэцэрлэг байгуулагдсан түүхтэй.

2022 он хүртэл 72 жилийн хугацаанд бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын олгож ирсэн нэгэн жаранг үдсэн түүхэн цэцэрлэг.

Тус цэцэрлэгийн анхны барилга нь 1958 онд баригдаж, 100 хүүхдийн хүчин чадалтай, 4 бүлэгтэй ашиглалтад орж 2019 оныг хүртэл 61 жилийн хугацаанд үйл ажиллагааг явуулж ирсэн бөгөөд, барилгын насжилт дууссан тул 2019 оны 8 сард буугдаж, газар дээр нь 150 хүүхдийн хүчин чадалтай, 6 бүлэгтэй, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандартыг хангасан, орчин цагийн шинэ цэцэрлэгийн барилга баригдаж, 25 ажилтантай үйл ажиллагааг явуулж байна. Шинэ цэцэрлэгийн барилга баригдаж 2020 оны 05 сарын 27нд ашиглалтанд орсон нь, анх байгуулагдсан сар, өдөр яг давхцаж, гайхалтай учирал тохиол бүрдсэн. Дэлхий нийтэд тархсан ковидын цар тахлын улмаас шинэ цэцэрлэгийн нээлтийг хийж чадалгүй байсаар 2022 оны 8 сарын 25-ны билэгт сайн өдөр Шинэ цэцэрлэгийн барилгын нээлтийг хийсэн.

Тус цэцэрлэг нь 2021 оны 12 сарын 03-ны өдрөөс Олон Улсын “Эко сургууль цэцэрлэг хөтөлбөр”-т хамрагдан, хүүхдийн сурч хөгжих эрүүл, аюулгүй, ногоон орчныг бүрдүүлэн, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандартыг хэрэгжүүлж бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг хийж тогтвортой хөгжлийг дэмжигч Эко цэцэрлэг “Хүрэл гэрэгэ” өргөмжлөлийг авч 2023 онд Эко цэцэрлэг “Мөнгөн гэрэгэ”-ний болзолыг ханган ажиллаж байна.